

Хөгжил дэвшлийг хамтдаа бүтээе!



ХАНБОГД СУМЫН ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ
2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

АГУУЛГА

- Мэндчилгээ

- 1-Р БҮЛЭГ. ЗАСАГЛАЛ

1.1 Зөвлөлийн удирдлага

1.2 Зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн

1.3 Зохион байгуулсан хурал, сургалт арга хэмжээ

1.4 Хяналт үнэлгээ

1.5 Мэдээллийн ил тод байдал

1.6 Санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэсэн байдал

- 2-Р БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1 Тайлант онд зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлсэн ажлууд

2.1.1 Усан хангамж

2.2 Оюутны сургалтын тэтгэлэгт хөтөлбөр

2.3 “Ундайн өв соёл” төсөл

2.4 Хамтын оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2.5 Малын тэжээлийн туршилтын төсөл

Хавсралт 1. Гэрээний хэрэгжилт 2024 он

-



МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт уншигч та бүхэндээ Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг өргөн барьж буйдаа туйлын баяртай байна. Бидний хамтын хүчин чармайлт, итгэл зүтгэлийн үр дүнд өнгөрсөн жил олон ажлуудыг амжилттай хэрэгжүүлж ирлээ.

2017 оны 5 дугаар сарын 9-ний өдөр Ханбогд сумын Засаг захиргаа, Малчид, “Оюу Толгой” компани хамтран байгуулсан Малчдын гомдол барагдуулах хоёр багц гэрээний хүрээнд нийт 60 гаруй ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан билээ. Гурван талт зөвлөлийн дотоод үнэлгээгээр хоёр гэрээний хэрэгжилт 74 хувийн гүйцэтгэлтэй байна.

2024 онд бид нийт 29 ажлыг хэрэгжүүлэхээр зорилт тавьж, оны төгсгөлд биелэлтийг нь эргэн дүгнэн, үргэлжлүүлэх шаардлагатай заалтуудыг 2025 оны төлөвлөгөөнд нэмж тусгасан.

2024 оны онцлох амжилтуудаас дүрдвал, мал нядлах, мах бэлтгэх үйлдвэрийн зураг төслийг боловсруулж, барилгын ажлыг 2025 онд эхлүүлэхээр төлөвлөсөн. Мөн малын тэжээлийн ургамал тарьж түрших, малчдын усан хангамжийг сайжруулах зорилгоор Ханбогд сумын дөрвөн багт 4 гүн өрмийн худаг, 16 сайжруулсан гар худаг шинээр гаргаж, 8 гар худгийг сэргээн засварлан, 8 нарны толийг малчдын худагт суурилууллаа. Үүнээс гадна дотоодын их, дээд сургуульд суралцаж буй малчин өрхийн 32 оюутанд сургалтын төлбөрийн 50 хувийн тэтгэлэг олгох ажлыг амжилттай хэрэгжүүлсэн.

“Ундайн өв соёл” сургалтын төсөл, “Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг”-ийн хөтөлбөрүүдийг ахмад буурал болон малчидтай хамтран 7 дахь жилдээ үргэлжлүүлэн хэрэгжүүлж буйг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд “Оюу Толгой” ХХК 2017–2024 онд нийт 15 тэрбум гаруй төгрөгийг зарцуулсан нь бидний хамтын амжилтын илэрхийлэл юм.

Гурван талт зөвлөлийн хамтдаа тавьсан зорилго, итгэлцэлд суурилсан хамтын ажиллагаа, амжилт бүтээлээр дүүрэн 10 жилийн түүхэн ойн баярыг 2025 ондоо угтаж байгаадаа туйлын баяртай байна. Энэ хүндэт ойг угтан, Гурван талт зөвлөлийн үйл ажиллагаанд хамтран зүтгэж, идэвхтэй оролцсон үе үеийн Орон нутгийн удирдлага, “Оюу Толгой” компанийн хамт олон, Ханбогд сумын малчдын төлөөллүүдээ чин сэтгэлийн талархалыг Гурван талт зөвлөлийн нэрийн өмнөөс дэвшүүлж байгаадаа таатай байна.

Ирээдүйд энэхүү итгэлцэл, хамтын ажиллагаа улам бүр өргөжиж, бидний хамтын зорилго бүрэн биелнэ гэдэгт бид гүнээ итгэж байна. Та бүхэндээ аз жаргал, эрүүл энх, ажлын өндөр амжилт хүсэн ерөөе!

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүд



Б.АЛТАНГЭРЭЛ

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүн, Ханбогд сумын Засаг даргын орлогч



Ч.НАМНАНСҮРЭН

Гурван талт зөвлөлийн ахлагч, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл



С.ДОРЖДЭРЭМ

Гурван талт зөвлөлийн удирдах нэгжийн гишүүн “Оюу толгой” ХХК-ийн орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг түншлэлийн менежер

01 ЗАСАГЛАЛ

1.1 ЗӨВЛӨЛИЙН УДИРДЛАГА

Гурван талт зөвлөлийн дүрэмд зааснаар Зөвлөлийн шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Түүнчлэн Зөвлөлийн ахлагчаар талуудыг ахлаж буй гишүүд жил бүрээр ээлжлэн ажиллах дүрмийн зохицуулалттай. Дүрмийн дагуу 2024 оны 6 дугаар сараас эхлэн Малчдын төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Жавхлант багийн малчдын төлөөлөл Ч.Намнансүрэн зөвлөлийн даргаар ажиллаж байна.

ГТЗ-ийн Удирдах нэгжийн бүрэлдэхүүнд “Оюу толгой” ХХК-ийн төлөөллийн ахлагч, Орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг, түншлэлийн менежер С.Дорждэрэм, орон нутгийн Засаг захиргааны төлөөллийн ахлагч, Ханбогд сумын Засаг даргын орлогч Б.Алтангэрэл нар тус тус ажиллаж байна. 2024 онд зөвлөл Хараат бус нарийн бичгийн байгууллагын дэмжлэгийг авч ажиллаа.

1.2 ЗӨВЛӨЛИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДХҮҮН

• “Оюу толгой” ХХК-ийн төлөөлөл

- С.Дорждэрэм (Орон нутгийн харилцааны хэлтсийн дэмжлэг, түншлэлийн менежер)
- Л.Мөнх-Оргил (Уурхайн үйл ажиллагаа хариуцсан ерөнхий зөвлөх)
- Т.Самданжигмэд (Байгаль орчны хэлтсийн менежер)
- П.Золбуянхишиг (Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн)
- Д.Саян (Орон нутгийн харилцааны хэлтсийн мэргэжилтэн)

Орон нутгийн Засаг захиргааны төлөөлөл

- Б.Алтангэрэл (Ханбогд сумын Засаг даргын орлогч)
- Э.Жамбалсанжид (Ханбогд сумын Жавхлант багийн Засаг дарга)
- М.Мягмаржав (Ханбогд сумын Баян багийн Засаг дарга)
- М.Сүглэгмаа (Ханбогд сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн)

• Малчдын төлөөлөл

- Ч.Намнансүрэн (Жавхлант багийн малчдын төлөөлөл)
- Н.Ширнэн (Жавхлант багийн малчдын төлөөлөл)
- Э.Сүрэнхорол (Жавхлант багийн малчдын төлөөлөл)
- М.Батхүү (Баян багийн малчдын төлөөлөл)
- Р.Бадамдорж (Баян багийн малчдын төлөөлөл)
- Х.Энхбат (Баян багийн малчдын төлөөлөл)
- Х.Далантай (Номгон багийн малчдын төлөөлөл)
- Ч.Сувдаа (Номгон багийн малчдын төлөөлөл)
- У.Гантөмөр (Номгон багийн малчдын төлөөлөл)
- Ч.Одмаа (Гавилууд багийн малчдын төлөөлөл)
- Д.Эрдэнэцэцэг (Гавилууд багийн малчдын төлөөлөл)
- З.Цогбаяр (Гавилууд багийн малчдын төлөөлөл)



Гурван талт зөвлөлийн гишүүд

1.3 ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУРАЛ, СУРГАЛТ АРГА ХЭМЖЭЭ

ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛ, УДИРДАХ НЭГЖИЙН ХУРАЛ

Гурван талт зөвлөлийн дүрэмд заасны дагуу тайлант онд зөвлөлийн хурлыг бүх гишүүдийн оролцоотойгоор 1, 4, 7, 9, 12 саруудад нийт 5 удаа, удирдах нэгж нийт 9 удаагийн хурал зохион байгууллаа. Эдгээр хурал, уулзалтаар цаг үеийн асуудлыг хэлэлцэхээс гадна хэрэгжилт удааширч буй төсөл арга хэмжээний биелэлтийг эрчимжүүлэх, зөвлөлийн хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцэх асуудал, хөтөлбөр бэлтгэх зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.



ГУРВАН ТАЛТ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДИЙН СУРГАЛТ

Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зөвлөлийн гишүүдэд зориулсан сургалтыг Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтаар гишүүдийн тэгш оролцоог хангах, багаар ажиллах чадварыг бэхжүүлэх зорилгоор “Дэйл карнеги трэйнинг” сургалтын байгууллагын багш нар дасгал ажил болон холбогдох сургалт арга зүйн зөвлөгөө өгөв.



“ГҮНЭЭСЭЭ ХАЙРЛАЯ” ХАНБОГДЫН УСНЫ ЧУУЛГАН

“Гүнээсээ хайрлая” газрын доорх усны мэдээллийн аяны хүрээнд Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн санаачлагаар Эх дэлхийн өдрийг тохиолдуулан Монголын Гидрогеологи, геоэкологийн холбоо, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газар, Ханбогд сумын Засаг даргын Тамгын газар, “Оюу толгой” ХХК, Гурван талт зөвлөл хамтран Өмнөговь аймгийн Ханбогд суманд 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр чуулганыг зохион байгууллаа.

Чуулганд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, Монголын Гидрогеологи, геоэкологийн холбоо, Газарзүй геоэкологийн хүрээлэн, ШУТИС, “Мөнх ногоон Галба” төрийн бус байгууллага, Монголын Дата клуб,

“Эрдэнэс Оюутолгой” ХХК болон “Оюу толгой” ХХК-ийн холбогдох албан хаагчид оролцож, мэдээлэл танилцуулга өгөв.

Монгол улсын газрын доорх усны нөөцийг хамгаалах, судлах, ари्वлан хэмнэх, нөөцийн чанарын судалгаа, хяналт шинжилгээ, бүс нутгийн усны экосистемийн тэнцвэрт байдлыг тогтвортой хадгалахад чиглэсэн төсөл хөтөлбөрүүд, судалгааны тайлан мэдээлэлтэй орон нутгийн иргэд танилцаж санал солилцлоо.

Чуулганы үеэр зөвлөлийн нарийн бичиг “Гурван талт зөвлөлийн бэлчээрийн усан хангамжийг сайжруулах ажлын тайлан”-г оролцогчдод танилцуулав.



ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД ОЮУ ТОЛГОЙ УУРХАЙН ТАЛБАЙД АЖИЛЛАВ

Зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу зөвлөлийн гишүүд 2024 оны 04 сард Оюу толгой уурхайн талбайн орчимд ажиллаж, Малчдын гомдол барагдуулах гэрээний хүрээнд хийхээр тохирсон зарим ажлын явцыг газар дээр нь үзэж танилцав.

АЖЛЫН ТАЛБАР:

- Оюу толгой уурхайн баяжуулах үйлдвэрийн ус дахин ашиглалтын хэсэг
- Уурхайн хашаан доторх Ундайн гол дээгүүрх хөндлөн гарсан замууд
- Ундай голын гольдрол өөрчилсөн хэсгийн мониторингийн цэг
- Дугатын худаг, Дугатын сайр
- Уст баг модны хөв цөөрөм
- Хаягдлын далангийн шүүрлийн мониторингийн цэгүүд
- Шинэ Бор овоогийн задгайн ургамалжуулсан талбай
- Уурхайн хашааны баруун талаар Төмөр замын маршрут, ачааны машины нэвтрэх хаалганы төлөвлөж байгаа байршил
- Дэлийн бууцны шороон замын нөхцөл байдал,
- Хаягдал хадгалах сангийн шүүрэл цуглуулах хэсэг, Хаягдал хадгалах 2-р далангийн ашиглалт, Хаягдал хадгалах 1-р далангийн нөхөн сэргээлтийн нөхцөл байдал



БАГУУДЫН ИРГЭДИЙН НИЙТИЙН ХУРАЛД ОРОЛЦОЖ МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭВ

Ханбогд сумын 5 багийн нэгдсэн Иргэдийн Нийтийн Хурал 2024 оны 03 сард Ханбогд сумын төвд зохион байгуулагдсан. Хурлаар Гурван талт зөвлөлийн Хараат бус нарийн бичгийн байгууллагын зүгээс зөвлөлийн шийдвэр, санаачлагаар 2023 онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн, цаашид анхаарах асуудал, мөн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар мэдээлэл өглөө.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ТӨЛӨӨЛЛҮҮД ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАЖ, ТУРШЛАГА СУДЛАВ

Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл 2024 оны 11 дүгээр сард Ханбогд суманд ажиллах үеэр зөвлөлийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах арга хэмжээг зохион байгуулав. Бүсийн төлөөллүүд зөвлөлийн сайн туршлагаас судлаж, тухайн бүс нутгийн онцлогт тулгуурлан хэрхэн зохион байгуулалт хийх, анхаарах асуудал болон зөвлөл байгуулагдсанаар бий болсон давуу тал, сорилтуудын талаар хэлэлцэж санал солилцов.



1.4 ХААЛТЫН АУДИТ

Оюу толгой төслийн орчимд амьдарч байсан 10 өрхтэй 2004 онд Нүүлгэн шилжүүлэлтийн гэрээ, мөн төслийн барилгын үе шатны нөлөөллийг бууруулах зорилгоор 2011 онд 89 өрхтэй Эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн гэрээг тус тус байгуулсан. Эдгээр 89 өрхийн гэрээний хэрэгжилтэд хөндлөнгийн үр дүнгийн үнэлгээг 2018 онд хийлгэсэн бөгөөд гэрээ байгуулахаас өмнөх үетэй харьцуулахад амьжиргаа нь сайжирсан 72 өрхийн гэрээг хаахыг зөвлөсөн. Улмаар амьжиргаа нь сайжраагүй 11 өрхтэй, Өрхийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулж ажиллах, мөн Оюу толгой уурхайгаас ус зөөвөрлөж байсан 5 өрхийн усан хангамжийг сайжруулах тухай зөвлөсөн болно. Зөвлөмжийн дагуу компаниас 16 өрхөд шаардлагатай дэмжлэгийг үзүүлж, 2024 онд Хаалтын аудитыг хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлсэн. Гүйцэтгэгчээр “Састэйнабилити Ийст Эйжия” ХХК, Монголын хараат бус судалгааны хүрээлэн (IRIM) хамтран ажилласан болно.

Хаалтын аудитын гол зорилго нь нөлөөлөлд өртсөн өрхүүд амьжиргаагаа тогтвортой сэргээж чадсан эсэх, НШҮАТ-ийн амлалт, зорилтууд дотоодын болон олон улсын стандартын дагуу биелсэн эсэхийг үнэлэхэд

оршино. Үнэлгээгээр талууд гэрээний үүргийг бүрэн хангаж ажилласан бөгөөд нөхөх олговрын гэрээг хаах нь зүйтэй гэсэн дүгнэлтийг гаргасан. Мөн “Оюу толгой” ХХК-ийг нийт малчдад чиглэсэн нийтийн нөхөх олговрын төслүүд болон эмзэг бүлгийн өрхүүдтэй үргэлжлүүлэн ажиллахыг зөвлөсөн байна. Хаалтын аудитын үнэлгээний тайланг гүйцэтгэгч байгууллагаас Ханбогд сумын Гурван талт зөвлөл, орон нутгийн удирдлага, төрийн бус байгууллагын төлөөлөл, судалгаанд хамрагдсан малчдад танилцуулсан болно.



ХАНБОГД СУМЫН ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОРИУЛАЛТЫН УС ХАНГАМЖИЙН СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА

Ханбогд сумын хөдөө аж ахуйн зориулалтаар ашиглах бага гүний уст давхаргын боломжит нөөц, уст цэгийн ашиглалтын зохистой горим, хөдөөгийн усны хэрэглээ, чанарыг тогтоох зорилго бүхий хөдөө аж ахуйн усан хангамжийн тогтвортой байдлын судалгааг Монголын Гидрогеологи, геоэкологийн холбоо эхлүүлсэн. Тус холбооны зүгээс 2024 оны 11 сард зөвлөлийн төлөөллүүдтэй үулзалт хийж, судалгааны ажлын танилцуулга, цаашид хэрхэн хамтран ажиллах талаар хэлэлцлээ.


Судалгааны ажлын үр дүнд:

- Уст цэгийн хүчин чадлыг бүрэн ашиглах боломж бүрдүүлэх
- Уст цэгийн бэлчээрийн хүрээний радиус, малын уух усны чанар, уст байрлал, төрөл, хүчин чадлыг сонгох тооцоо хийж ашиглалтын горимыг тогтоосноор уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, эрсдэлийг бууруулах зэрэг ач холбогдолтой юм.



1.5 МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

- Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг <http://tpc.mn/> цахим хуудаснаас авах боломжтой
- Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг албан ёсны фейсбүүк хуудас [Гурван талт зөвлөл/Tripartite Council](#)
- ГТЗ-ийн албан ёсны и-мэйл (tripartitecouncil.kb@gmail.com) хаягийг ГТЗ-ийн нарийн бичгийн ажилтан хариуцан ажиллаж байна.
- Түүнчлэн мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр 2024 онд Ханбогд сумын 4 багийн малчдыг төлөөлсөн гишүүдээр дамжуулан ГТЗ-өөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, арга хэмжээ болон цаг үеийн мэдээллийг хэвлэмэл тайлан хэлбэрээр бэлтгэж малчин өрх, оролцогч талуудад хүргүүлэв.



1.6 САНАЛ ХҮСЭЛТ, ӨРГӨДӨЛ ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2024 онд ГТЗ-д хандан, орон нутгийн 5 малчидаас гар худаг засварлуулах, технологийн худаг гаргуулах, нарны толь суурилуулах, оюутны тэтгэлэгч хөтөлбөртэй холбоотой ирүүлсэн хүсэлтүүдийг зөвлөлийн ээлжит хурлаар хэлэлцэж шийдвэрлэн хариуг нь хүргүүлэв.



Гурван талт зөвлөлийн үйл ажиллагааны мэдээ мэдээллийг <http://tpc.mn/> цахим хуудаснаас




Гурван талт зөвлөлийн албан ёсны фейсбүүк хуудас [Гурван талт зөвлөл/Tripartite Council](#)

02 ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ЗӨВЛӨЛИЙН ДОТООД ҮНЭЛГЭЭГЭЭР 74% -ТАЙ БАЙНА.

Энэхүү хоёр гэрээнд бэлчээр, ус, нөхөн олговор, нийтийн нөхөх олговор, мониторинг, Ундай зэрэг 6 дэдсэдвийн хүрээнд нийт 64 асуудлыг шийдвэрлэхээр тусгасан ба гэрээний хэрэгжилт 2022 оны зөвлөлийн дотоод үнэлгээгээр 74% гүйцэтгэлтэй байна. Уг хоёр гэрээ болон зөвлөлийн дүрмийн хэрэгжилтийн хөндлөнгийн үнэлгээг 2025 онд хийлгэхээр төлөвлөсөн.



- 96% Нөхөх олговор
- 84% Ундай
- 81% Мониторинг
- 79% Бэлчээр
- 64% Ус
- 41% Нийтийн НО

2.1 2024 ОНД ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭРЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛУУД

2.1.1 УСАН ХАНГАМЖ

Ханбогд сумын “Гурван талт зөвлөл”-ийн малчдын гомдлыг барагдуулах гэрээгээр хэрэгжүүлэхээр тохирсон ажлын хүрээнд эвдэрч муудсан худгуудыг сэргээн завсарлах, технологийн худаг шинээр гаргах, малчдын гүн өрмийн худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж байна. Усан хангамжийг сайжруулах

ажилд “Оюу толгой ХХК”-иас 4 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт олгоод байна. Худаг засварлах болон шинээр гаргах, нарны толь суурилуулах хүсэлтэй малчдын худгийг сонгохдоо Ханбогд сумын багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэдэг. Гүйцэтгэгчийг “Оюутолгой” ХХК-иас жил бүр орон нутагт тендер зарлан сонгодог.

2019 оноос хойш бэлчээрийн усан хангамжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн ажил:

- Нарны толь суурилуулалт – 50 худаг
- Технологийн худаг (худгийн байшин, нарны тольтой) – 28,
- Гар худаг засвар – 88 худаг
- Гүний худаг (худгийн байшинтай) – 14

МАЛЧДЫН ГҮН ӨРМИЙН ХУДАГТ НАРНЫ ЭРЧИМ ХҮЧЭЭР АЖИЛЛАДАГ УС ӨРГҮҮРИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ СУУРИЛУУЛАХ АЖИЛ

2024 онд уг ажлыг “Жинерал лайтс” ХХК гүйцэтгэсэн бөгөөд ногоон тэжээлийн ургамал тариалахтай холбоотой 8 худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийн тоног төхөөрөмж суурилуулав.

Нарны толь суурилуулсан нийт худгийн тоо (өрхөөр)

Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2022	22	“Оюу толгой” ХХК	Женераллайтас компани
2023	20	“Оюу толгой” ХХК	Батсэтгэл компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Женераллайтас компани
Нийт	50		





● МАЛЧДЫН ГАР ХУДАГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ АЖИЛ

Уг ажлын хүрээнд хуучин эвдэрч муудсан худгууд болон зун намрын отрын бүсийг усжуулах зорилгоор малчдын гар худгийг сэргээн завсарлах ажлыг 2019 оноос гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар нийт 88 гар худгийг сэргээн засварлаад байна. Ханбогд сумын Засаг даргын Тамгын газраас томилогдсон ажлын хэсэг засварласан худгуудыг хүлээн авч худаг эзэмшигч малчдыг байлцуулан, гүйцэтгэлийн чанарт тэдний саналыг тусгаж ажилладаг. 2024 оны гар худаг засварын гүйцэтгэгчээр “Батсэтгэл” ХХК ажиллаа.



Гар худаг сэргээн засварласан нийт тоо

Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2019	16	Худаг эзэмшигч, “Оюу толгой” ХХК	4 Хоршоо, 1 ТББ
2020	20	“Оюу толгой” ХХК	Ханжавхлант компани
2021	20	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2022	16	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2023	8	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Батсэтгэл компани
Нийт дүн	88		

● ТЕХНОЛОГИЙН ХУДАГ

Гурван талт зөвлөлийн шийдвэрээр хэрэгжүүлж буй ажлуудын нэг нь худгийн ундаргыг нэмэгдүүлэх, үерийн хүчтэй урсгалд худгийн ам дарагдахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж буй технологийн худгийн ажил юм. 2022 оноос хойш зөвлөлийн зүгээс санаачлан нийт 28 худгийг байшин болон нарны тольтой цогц хэлбэрээр хэрэгжүүллээ. Ингэснээр малчдын эдийн засагт хэмнэлттэй, ажлыг хөнгөвчлөх зэрэг ач холбогдолтой ажил юм.



Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2022	4	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2023	16	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
2024	8	“Оюу толгой” ХХК	Ботгон хөөвөр компани
Нийт дүн	28		

• ГҮНИЙ ХУДАГ ГАРГАХ

Гурван талт зөвлөлийн шийдвэрээр Ханбогд сумын 4 багийн нутаг дэвсгэрт 4 гүн өрмийн худаг гаргах ажил үргэлжилж байна. 2023-2024 онд зөвлөлийн зүгээс санаачлан нийт гүний худгийн байшин, мотор бүхий иж бүрэн 14 худаг гаргасан.

Хэрэгжсэн он	Худгийн тоо	Санхүүжүүлэгч	Гүйцэтгэгч байгууллага
2023	10	Оюутолгой ХХК	Эрдэнэ дриллинг компани
2024	4	Оюутолгой ХХК	Эрдэнэ дриллинг компани
Нийт дүн	14		



2.2 ОЮУТНЫ СУРГАЛТЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

Гурван талт зөвлөлийн санаачлага, “Оюу толгой” ХХК-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Малчин өрхийн оюутны тэтгэлэгт хөтөлбөр”-ийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургуульд суралцаж буй Ханбогд сумын малчин өрхийн оюутнуудад мэргэжил болон курс харгалзахгүйгээр тодорхой шалгуурыг хангасан 32 оюутанд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олголоо. Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2017-2021 он, 2023-2024 онуудад нийт 250 сая төгрөгийн санхүүжилтийг 50 гаруй малчин өрхийн оюутанд олгосон байна.



2.3 “УНДАЙН ӨВ СОЁЛ” ТӨСӨЛ



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Жавхлант багийн нутаг Ундайн гол дагуух өрхүүдийн ахмад настнууд “Уламжлалт мал аж ахуйн өв, мэдлэгээ залуучуудад таниулан түгээх, зөвлөх, уламжлах сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” зорилго бүхий төслийг 2019 оны 6 дүгээр сараас Ханбогд сумын Ахмадын хороотой хамтран хэрэгжүүлж эхэлсэн билээ.

Ундайн голын өв соёл төсөлд хамрагдаж байгаа ахмадууд төслийнхөө зорилго үйл ажиллагааг сайтар ойлгож үр хүүхэд ач зээ, гол усныхандаа өөрийнхөө мэддэг чаддаг бүхнээ заан сургаж өвлүүлэхээр чармайн ажиллаж байна. Төслийн үйл ажиллагааг танилцуулах, таниулах зорилгоор “Оюу толгой” ХХК-ийн орон нутгийн сонин болон нийгмийн сүлжээг ашиглаж төслийн талаар мэдээлэл болон төсөлд оролцогч ахмад настнуудаас цувралаар яриа бэлтгэж олон

сар бүр хүргэж байна. Энэхүү төсөл нь 6 жил тасралтгүй үргэлжилж байгаа бөгөөд давхардсан тоогоор 284 ахмад настан 14,000 гаруй иргэнд говийн ёс заншил, өв уламжлал, өөрийн амьдралаар олж авсан мэдлэг мэдээллээ залуу хойч үедээ зааж сургаж өвлүүлэн үлдээж байна. Ингэснээр говь нутгийн өвөрмөц соёлын өвд болон биет бус өв мартагдаж бүдгэрэн алга болох эрсдэлд бага ч болов энэ төслөөр дамжуулан хэрэгжиж байна. Үг төслийн хүрээнд 2019-2024 онд “Оюу толгой” ХХК-иас 400 гаруй сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Огноо	Ахмадын тоо (давхардсан)	Сургалтын тоо	Сургалтад хамрагдсан хүний тоо
2019	38	266	2236
2020	54	162	1198
2021	55	220	2728
2022	70	267	3178
2023	67	253	2542
2024	74	287	2432
Нийт	284	1168	14304



Ахмадуудын сургалтын явц

2.4 ХАМТЫН ОРОЛЦООТОЙ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР



Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гурван талт зөвлөлийн шийдвэр, малчдын гомдлыг барагдуулах гэрээ 1-ийн 3.1 дэх заалтад нутгийн иргэдийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг шинэчлэн сайжруулж хэрэгжүүлэх тухай тусгагдсан байдаг. Ингэхдээ иргэд малчид чин сэтгэлээсээ оролцож хариуцлагатай хандах, мэргэжлийн түвшинд байгаль орчны хяналт шинжилгээг хийх хэмжээнд чадавхжуулах, арга зүйг мал маллагааны хэв маягтай уялдуулан зохицуулсан шинжлэх ухааны үндэслэлтэй талуудын итгэл үнэмшлийг хангасан байхаар шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх явдал байв. Ханбогд сумын иргэд, малчид сайн дураараа эвлэлдэн нэгдэж “Мөнх ногоон Галба” ТББ-ыг үүсгэн байгуулж 2018 оны 08 сарын

01-ний өдрөөс эхлэн албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлж “Хамтын оролцоотой хяналт шинжилгээ” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. “Мөнх Ногоон Галба” ТББ -ын эрх барих дээд байгууллага нь “Удирдах зөвлөл” бөгөөд тал бүрийн оролцоог хангасан 9 гишүүнтэй, гүйцэтгэх захиргаа буюу байнгын ажлын байранд гүйцэтгэх захирал, менежер, нягтлан бодогч, байгаль орчны мэргэжилтэн, жолооч нийт 8 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна.

2024 оны байдлаар Ханбогд сумын хэмжээнд ус, агаарын чанар, бэлчээр ургамал, зэрлэг амьтны хяналт шинжилгээ гэсэн 4 үндсэн чиглэлд 176 байршилд 151 малчинтай хамтран 5 дахь үйл ажиллагаа явуулж байна. “Мөнх ногоон галба” ТББ нь хяналт шинжилгээний ажлынхаа чанар хүртээмжийг сайжруулах, оролцогч иргэд малчид, мэргэжилтнүүдийнхээ чадавхыг дээшлүүлэх зорилгоор орон тооны бус эрдэмтдийн зөвлөх багийг ажиллуулж байна. Уг ТББ-ийн санхүүжилтэд “Оюу толгой” ХХК-иас 1 тэрбум гаруй төгрөгийн санхүүжилт олгоод байна.

УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Энгийн гар худаг: Сүүлийн жилүүдэд хур бороо бага орсонтой холбоотой худгийн ус бага зэргийн татарч байсан бол энэ 2024 оны 7,8 сард хур бороо элбэг орсонтой холбоотой худгийн усны түвшин хэвийн түвшиндээ хүрсэн. Энгийн гар худгуудын түвшний хэлбэлзэл 0,01м-0,1м хооронд байсан ба хамгийн их түвшний хэлбэлзэлтэй худаг нь Гавилууд багийн малчин Ш.Ганбатын “Дунд Халив” худаг 1,6м байлаа.

Өрөмдмөл худаг: Ханбогд сумын 4 багийн малчдын 8 малчны гүний худгийг улирал тутамд 1 удаа зөөврийн гар багажаар хэмждэг. Худгуудын түвшний хэлбэлзэл 0,1-0,40м байлаа. Хамгийн өндөр түвшний хэлбэлзэлтэй худаг Жавхлант багийн малчин Д.Намсрайн “Зүрх салаа” худаг байлаа.



Булаг задгайн мониторинг: Багийн нутаг дэвсгэрийг хамарсан 6 булаг задгайг улирал тутамд хэмжиж байна. 2024 оны байдлаар хур тунадас муу орсонтой холбоотой булгийн ус бага зэргийн татарсан. 7,8 сарын хур борооноор татарсан байсан булгийн ус сэргэж, ундарч эхэлсэн.

Хяналтын цооног: Гүний хоолойн хяналтын 2 цооногийн усны түвшинг сар бүр тогтмол хэмждэг. Усны түвшний хэлбэлзэл нь 0,05 м-0,9 м хооронд хэлбэлзэлтэй байлаа.

Чанарын шинжилгээ: “Нанна” гар багажаар усны орчин, цахилгаан дамжуулах чадвар, эрдэсжилтийг үздэг. Сар бүр 5-8 малчдын энгийн гар худгийн усны чанарыг шалган мэдээлэл цуглуулж мэдээллийн сан үүсгэдэг ба малчдад танилцуулдаг.

ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Малчдын оролцоотой тогтсон замналын дагуу сар бүрийн 20-25-ны хооронд явж тааралдсан Хулан, Хар сүүлт, Аргал, Янгир зэргийг бүртгэн ажиглалтаа хийдэг. 2024 оны хагас жилд нийт 831 тууртан амьтан ажиглагдсан. Мөн хөдөлгөөн мэдрэгч автомат камерыг ашиглан 3 уст цэгт 47 хоног байршуулахад Чоно, Үнэг, Шилүүс, Тууртан амьтад болох Аргаль, Янгир, Хулан, Хар сүүлт зэрэг ажиглагдсан.

Шувууны судалгаа: Хаягдлын сан орчим буюу Бор Овоогийн задгайн уст цэгт 4-5-р сард шувууны ажиглалт хийж, нүүдлийн шувуу 92, суурин шувуу 22, нийт 114 шувуу бүртгэсэн.



БЭЛЧЭЭРИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

Ханбогд сумын бэлчээрийн хэв шинжийг төлөөлөхүйц 18 цэгт, 8 малчин, доктор, дэд профессор П.Ариунсүрэнтэй хамтран бэлчээрийн төлөв байдлын ажиглалтын арга зүйг ашиглан 2024 оны 08 дугаар сарын 2-р 7 хоногт бэлчээрийн судалгааг хийсэн. Мөнх ногоон галба ТББ нь 2020 оноос хойш бэлчээрийн төлөв байдлын судалгааг малчдын оролцоотой жил бүр хийж, судалгааны мэдээг DIMA программд оруулж, мэдээллийн сан бүрдүүлдэг.

Тооройн хяналт шинжилгээ: Ханбогд сумын Уртын гол, Хөх дэлийн тоорой модны судалгаа, тооройн төглийн хашаа хамгаалах ажлыг 2020 оноос хойш жил бүр Жавхлант багийн малчин О.Хоролсүрэн, Б.Бямбадэлгэр нартай хамтран хийсэн. Уртын гол, Хөх дэлийн тоорой мод өвчилсөн тул навчнаас дээж авч ХААИС-д шинжлүүлсэн. Дээжийг PDA тэжээлт орчинд 250C ургуулан цэвэр өсгөвөр гаргаж, өвчин үүсгэгчийг колони морфологи, спортын хэлбэрээр Алтернариоз (*Alternaria* spp) өвчин болохыг тодорхойлсон.

Яшил модны тооллого: Удирдах зөвлөлийн дарга Д.Буянтогтох, Баян багийн малчин Б.Дүнжгэр Жавхлант багийн малчин Оюунтулга, Гавилууд багийн малчин Д.Баяраа нартай хамтран 2024 оны

10-р сарын 30-наас 11-р сарын 08-нд Улаан модот яшилын тооллогын ажлыг эхлүүлэн 173 ширхэг яшил модыг тоолж бүртгэсэн. Яшил нь бараан саарал юм уу хар хальстай, ихэд салаалан тахиралдсан ба өргөстэй, мод нь хатуулаг бөгөөд улаан хүрэн өнгөтэй, 2 метр орчим өндөр сөөг юм. 5-р сард цэцэглэж, 7-8 сард үрлэнэ. Хангай говийн чулуурхаг бэл, асга хад хярд ургадаг.



ТООСЖИЛТЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ



Тоосны хяналт шинжилгээг 2024 оны 01-12-р сард нийт 9 цэгт (Ханбогд сумын төвд 4 цэг, Оюу толгой уурхайн орчимд 3 цэг, Манлайн зам дагуу 2 цэгт) DUSTTRAK 8533 багажийг ашиглан 2 малчинтай хамтран хийж, мэдээг боловсруулсан. Ханбогд сум болон Оюу толгой уурхай орчимд агаар дахь нарийн болон бүдүүн ширхэглэгт тоосны агууламж Монгол улсын агаарын чанарын MNS4585:2016 стандартад нийцэж байна. Ханбогд сум хойд болон зүүн талын хэсгээр засмал зам тавьснаар тоос шороо өмнөх жилүүдээс харьцангуй бага болсон.

2.5 МАЛЫН ТЭЖЭЭЛИЙН ТУРШИЛТЫН ТӨСӨЛ

Төслийн зорилго:

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт 1 наст тэжээлийн таримал ургамал тариалж, зохистой хувилбарыг сонгох, тариалсан ургамлаар тэжээл бэлтгэх, бэлтгэн таримал тэжээл үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг тооцох, цөл, цөлөрхөг хээрийн нөхцөлд таримал тэжээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг судлан үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор туршилтын ажлыг хэрэгжүүлсэн. Тэжээлийн ургамлын тариалах туршилтанд малчин өрхүүдийг сонгохдоо хөрсний ялзмаг, хөрсний орчин, хөдөлгөөнт эрдсийн агууламжид тулгуурлан 8 малчин өрхийг сонгон малын тэжээлийн нэг наст ургамал тарималжуулах туршилтыг хэрэгжүүлсэн. Туршилтийн ажлын зөвлөх, чиглүүлэх байгууллагаар Хөдөө аж ахуйн их сургууль ажиллаж байна.

Төслийн үр дүн:

- Өмнөговь аймгийн Ханбогд сумын хөрс, усны дээж авч найрлагыг тодорхойлогдож, тухайн хөрс байгаль цаг уурын онцлогт тохирсон үрийн сонголт хийгдэнэ.
- Ханбогд суманд тариалах тэжээлийн 1 наст ургамлын тохиромжтой хольц, тариалах технологи, услах, бордох хэмжээ тогтоогдоно.
- Эдийн засгийн үр өгөөж тогтоогдоно.
- Таримал ургамлаар тэжээл бэлтгэх технологийг нутагшуулна.
- Таримал тэжээл болон, даршны химийн найрлага, шингэц, шимт чанарыг тодорхойлсны үндсэн дээр малын тэжээлийн тохиромжтой 2-3 жортой болно.
- Ханбогд суманд 1 наст тэжээлийн таримал ургамал тариалах, таримал тэжээлээр дарш бэлтгэх технологи, малын тэжээлийн жор боловсруулах заавар, зөвлөмж, гарын авлагатай болно.
- Туршилтын ажлын тайлан боловсруулах ажил хийгдэж байгаа.



НӨХӨН СЭРГЭЭЛТ

“Оюу Толгой” компанийн Байгаль орчны хэлтэс 2022–2026 онд Ханбогд сум болон Манлай сумыг холбосон сайжруулсан шороон замын хажуугийн салаа замуудын талбайн хэмжээтэй дүйцэхүйц, нийт 32 га газарт бэлчээрийн нөхөн сэргээлт, сайжруулалтын ажил хийхээр төлөвлөсөн. Тус төлөвлөгөөний хүрээнд 2022, 2023 онд 8 га талбайд бэлчээрийн ургамал тарьж, 2024 онд эдгээр талбайн усалгаа, арчилгааны ажлыг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэлээ.





Гурван Талт Зөвлөлийн үйл ажиллагааны мэдээллийг:

 tpc.mn

 Гурван талт зөвлөл/Tripartite Council

 tripartitecouncil.kb@gmail.com